

2025, 10, 23

№ 25/23

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь Ард Кредит Плас ХХК болон Ард актив ХЗХ хооронд 2025 оны 9 сарын 30-ны өдөр байгуулсан №MN121300013810 тоот зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах хүрээнд батлан даагчаар оролцохыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Дээрх зээлийн гэрээгээр Ард Кредит Плас ХХК нь 2,500,000,000 төгрөгийн бизнесийн зээлийг жилийн 24 хувийн хүүтэй, 24 сарын хугацаанд сар бүр хүүгийн төлөлт, хугацааны эцэст үндсэн төлбөр төлөх нөхцөлтэйгөөр Батлан даалтын гэрээг байгуулахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Ард актив ХЗХ-той батлагааны гэрээ байгуулах, үүнтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч. ГАНХУЯГ

2025/ 10 / 23

№ 25/24

Улаанбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Охин компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг томилах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь Ард Финтек Солюшн ХХК-ийн 100 хувийн энгийн хувьцаа эзэмшигч болохыг **ДУРДСУГАЙ.**
2. Дараах этгээдийг Ард Финтек Солюшн ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр 2025 оны 10 сарын 23-наас эхлэн **СОНГОСУГАЙ.** Үүнд:
 1. Батбилэгийн Золбоо
 2. Чулууны Ганхуяг
 3. Бямбасүрэнгийн Баттулга

ДАРГА



Ч.ГАНХУЯГ